

МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2022 оны \_\_ сарын \_\_ өдөр

Дугаар \_\_

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Оюуны өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“ Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн мэдээллийн сайн дурын бүртгэл хөтлөх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /П.Сайнзориг/-д, үйл ажиллагаандаа мөрдөхийг Оюуны өмчийн газрын дарга /Г.Элбэгсайхан/-д тус тус үүрэг болгосугай.

Гарын үсэг

## **ЗОХИОГЧИЙН ЭРХ БОЛОН ТҮҮНД ХАМААРАХ ЭРХИЙН МЭДЭЭЛЛИЙН САЙН ДУРЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Зохиогч зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн бүтээлийн мэдээллийг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын (цаашид “оюуны өмчийн байгууллага” гэх) зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн мэдээллийн санд бүртгүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг шилжүүлэн авсан тухайн бүтээлийг эзэмших, ашиглах эрх бүхий иргэн, хуулийн этгээд тухайн бүтээлийг бүртгүүлэхэд энэхүү журмыг баримтлана.

### **Хоёр. Зохиогчийн эрхийн бүтээлийг бүртгүүлэх**

2.1.Зохиогч болон энэ журмын 1.2-д заасан иргэн, хуулийн этгээд тухайн бүтээлийг бүртгүүлэх тухай мэдүүлэгийг оюуны өмчийн байгууллагын зохиогчийн эрхийн асуудал хариуцах нэгжид гаргана.

2.2.Оюуны өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн бүтээлийн мэдээллийг бүртгүүлж болно.

2.3.Зохиогч сайн дурын үндсэн дээр зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн бүтээлийг бүртгүүлэхдээ цахим мэдүүлгийн маягтийг бөглөх бөгөөд дор дурдсан баримт бичгийг ирүүлнэ;

2.3.1.бүтээлийн танилцуулга /бүтээлийн ерөнхий агуулга, бүтэц, хэлбэр, хэмжээ, зорилго, ач холбогдол, онцлог зэргийг тусгана/;

2.3.2.зохиогчийн эрхийн бүтээлийг туурвисан нь үнэн болохыг өөрийн хамаарал бүхий иргэн, хуулийн этгээдээр тодорхойлуулсан баримт;

2.3.3.эх бүтээл;

2.3.4.үйлчилгээний болон улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

2.3.5.бусдын бүтээлийг өөрийн бүтээлд ашигласан бол тухайн бүтээлийн зөвшөөрлийг авсан тухай баримт;

2.4.Зохиогч албан үүргийн дагуу эсхүл, захиалгаар, гэрээ хэлцлээр зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн бүтээлийг эзэмших, ашиглах эрхээ иргэн, хуулийн этгээдэд шилжүүлж болох бөгөөд түүнийг шилжүүлэн авсан этгээд сайн дурын үндсэн дээр бүтээлийг бүртгүүлж болно.

2.5.Энэ журмын 2.4-д заасан шилжүүлэн авсан этгээд нь зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн бүтээлийг бүртгүүлэхдээ цахим мэдүүлгийн маягтийг бөглөх бөгөөд энэ журмын 2.3-т зааснаас гадна албан үүргийн дагуу, эсхүл

захиалгаар, гэрээ, хэлцлээр бүтээл туурвисан бол албан тушаалын тодорхойлолт, гэрээний хуулбарыг нотариатаар баталгаажуулсан хуулбарыг ирүүлнэ.

2.6.Энэ журмын 2.3.3-т заасан эх бүтээл нь дараах шаардлагыг хангасан байна:

2.6.1.бичмэл бүтээлийг хэвлэлийн бүтээгдэхүүний чанар стандартад нийцүүлсэн байх;

2.6.2.эхээр өгөх боломжгүй бүтээлийн эскиз болон фото зургийг ирүүлж болох бөгөөд фото зурагт тухайн бүтээлийн нэрийг бичсэн байх;

2.6.3.кино урлагийн болон дуу авиа бүхий дүрст бүтээлийн хувьд дижитал хэлбэртэй байх;

2.6.4.компьютерын программын хувьд “эх код”-ийг дижитал хэлбэрт хөрвүүлсэн байх.

2.7.Кино урлагийн болон дуу авиа бүхий дүрст бүтээлийг бүртгүүлэх тохиолдолд энэ журмын 2.3-т зааснаас гадна дор дурдсан баримт, бичгийг хавсаргана:

2.7.1.продюсер, зохиол бичсэн зохиогч, ерөнхий найруулагч, дууны найруулагчтай тус бүрд нь хийсэн гэрээ;

2.7.2.зохиогчийн эрх болон хамаарах эрхээ шилжүүлсэн бол гэрээ;

2.7.3.бүтээлд бусад төрлийн зохиогчийн эрхэд хамаарах бүтээлүүд орсон бол тухайн бүтээлийн зохиогч болон эрх эзэмшигчээс авсан зөвшөөрөл.

2.8.Зохиогчийн эрхийн мэдүүлгийн маягыг [www.ipom.gov.mn](http://www.ipom.gov.mn)-сайтаас татан авч, компьютероор бөглөн хэвлэж гарын үсэг зурсан байх бөгөөд эзэмшигч нь хуулийн этгээд бол тамга дарж баталгаажуулсан байна.

### **Гурав. Бүтээлийг бүртгэх, гэрчилгээ олгох**

3.1.Энэ журмын 2.1-д заасан байгууллага зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн бүтээлийг бүртгэж, зохиогчийн эрхийн нэг гэрчилгээ олгоно.

3.2.Энэ журмын 2.1, 2.4-д заасан этгээд нь энэ журмын 3.1-д заасан гэрчилгээг үрэгдүүлсэн, гээгдүүлсэн бол гэрчилгээ дахин олгох бөгөөд ж болно:

4.4.1.хүсэлт;

4.4.2.хүчингүйд тооцсон тухай зар;

4.4.3.гэрчилгээний хураамж төлсөн баримт.

3.3.Энэ журмын 2.1, 2.4-д заасан эрх эзэмшигч өөрчлөгдсөн бол бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулан, энэ журмын 3.1-д заасан гэрчилгээ олгоно

4.5.1.бичгээр гаргасан хүсэлт;

4.5.2.эрх шилжүүлсэн гэрээ болон холбогдох баримт бичиг;

4.5.3.гэрчилгээний хураамж төлсөн баримт.

3.4.Зохиогчийн эрхийн асуудал хариуцах нэгж нь энэ журмын 2.3, 2.5-д заасан баримт бичгийн бүрдэл, 2.6, 2.7-д заасан шаардлагыг хянаж, мэдүүлгийг хүлээн авч, ажын 14 хоногт багтаан шийдвэрлэнэ.

3.5.Энэ журмын 3.4 заасан баримт бичгийн бүрдэл, шаардлага хангаагүй бол мэдүүлгийг хүлээн авахгүй.

3.4.Мэдүүлэгт хавсарган ирүүлсэн баримт бичгүүдийн бүрэн бүтэн байдлыг мэдүүлэг хүлээн авсан бүртгэлийн мэргэжилтэн хариуцах бөгөөд бусдад дамжуулах, ашиглуулах, хуулбарлахыг хориглоно.

3.5.Бүртгэлийн мэргэжилтэн мэдүүлэг, түүнд хавсаргасан баримт бичиг, бүтээлийн эх хувийг архивын стандарт, журамд нийцүүлэн архивын ажилтанд хүлээлгэн өгөх үүрэгтэй.

4.6.Бүтээлийг бүртгэх гэрчилгээ олгохтой холбогдон үүссэн маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

--- оОо ---